

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАРИЛЦААНЫ ГОЛ ҮЙЛ ЯВДЛУУД

(2007 оны хоёрдугаар хагаст)

2007.07-р сар.

Батлан Хамгаалах Яамдын Зөвлөлдөх уулзалтыг Берлин хотноо зохиож, Германы талаас манай БХЯ-нд холбоо, эмнэлгийн зүйлийн тусламж үзүүлэв.

Берлин, Хамбург, Мюнхен хотуудад гарч буй эртний скифүүдийн тухай олон улсын томоохон үзэсгэлэнд Монгол Улсын нутаг дэвсгэрээс олдсон археологийн олдворуудыг дэлгэн үзүүлэв.

2007.07.03.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн XII хорооны өрхийн эмнэлэгт “Өрхийн амьжиргааг сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд ХБНГУ-ын Элчин сайдын яам, SOS хүүхдийн хотхонтой хамтран эхо болон цусны цагаан бөөмний шинжилгээ хийх орчин үеийн тоног төхөөрөмж, мөн хүүхдийн цахилгаан жин зэрэг 10 мянган ам.долларын бэлгийг хүлээлгэн өгөв. Хөтөлбөрийн нээлтэд ХБНГУ-ын ЭСЯ-ны 1-р нарийн бичгийн дарга, SOS хүүхдийн хотхоны Ерөнхийлөгч зэрэг хүмүүс оролцов.

2007.07.21.

Монголын байт харвааны баг тамирчид ХБНГУ-ын Лайпциг хотноо болсон Байт харвааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоод ирэв.

2007.08.04.-09.

Үндэсний Архивын Газрын дарга Д. Өлзийбаатарын урилгаар ХБНГУ-ын Холбооны Архивын Ерөнхийлөгч ноён Х. Вебер, мөн архивын гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн, доктор Кай фон Жена нар Монгол Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр хоёр тал цаашид хамтран ажиллах талаар харилцан тохиролцож гэрээ байгуулав. Төлөөлөгчид Үндэсний Төв Архивт зочлон баримт

хадгалалтын нөхцөл байдалтай танилцаж архивч ажилтан нартай уулзалт зохион байгуулав. Мөн зочидод Үндэсний Төв Архивын сан хөмрөг дэхь Монгол-Германы харилцааны холбогдолтой баримт бичгийн бичил үзэсгэлэн сонирхуулав.

2007.08.13-30.

ХБНГУ-ын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (ХЭЗХАХЯ)-ны санхүүжилтээр ГТХАН (GTZ), Монгол Улсын Газрын харилцаа, геодези, зураг зүйн газартай хамтран хэргжүүлж буй "Газрын менежмент ба санхүүгийн кадастр" төслийн хүрээнд 2007 оны зуны сургалтыг "Аж ахуйн зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, газрын харилцаа ба орон зайн мэдээллийн дэд бүтэц" сэдвээр зохион байгуулж, судлаач, мэргэжлийн хүмүүс, яамд, агентлаг, сум, дүүргийн газрын мэргэжилтнүүд, их, дээд сургуулийн багш, оюутнуудыг хамруулан зохион байгуулав. Уг сургалтыг зохион байгуулахад Шведийн "Газрын алба, захиргаадын хүний нөөцийг бэхжүүлэх нь" төсөл, МУИС, МУИС дахь Хөгжлийн судалгааны төв, Мюнхений Техникийн Их сургууль дэмжиж оролцов.

2007.08.15.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хдоронд байгуулах "Дарханы Дулааны цахилгаан станцын турбиныг шинэчлэх" зээлийн Хэлэлцээрийг зарчмын хувьд зөвшөөрч, УИХ-ын Байнгын хороодоор хэлэлцүүлж зөвшилцөхөөр болов.

2007.08.16.

Барилга, хот байгуулалтын сайд Ж. Наранцацралт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга Ш. Батсүх нар Мюнхений Техникийн Их сургуулийн профессор Холжер Мэгилийг хүлээн авч уулзан МУИС Мюнхений Техникийн Их сургуультай хамтран ажиллаж, газрын харилцаа, газар төлөвлөлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургалтад хамруулах, зуны сургалт зохион байгуулахаар тохиролцов.

2007.08.20-21.

ГТХАН-ын "Байгаль хамгаалал байгалийн нөөцийн тогтвортой менежмент" хөтөлбөрөөс санаачлан Ноён тур бааз дээр ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ТББ, байгаль хамгаалагчид зэрэг 80 оролцогчдын дунд "Ойн хуулийн хэрэгжилт ба засаглал" Анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулав.

2007.08.21-24.

Археологич эрдэмтдийн олон улсын ээлжит хуралдаан манай улсад эхлэв. Уг хуралдаанд Германы археологич эрдэмтэд оролцож, хоёр орны судалгаа, шинжилгээний салбарын хамтын ажиллагааны үр дүн, ололт амжилт, ойрын ирээдүйн зорилтынхоо талаар санал солилцов.

2007.08.22.

Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагаас зохион байгуулсан Монгол-Германы бизнес эрхлэгчдийн чуулга уулзалт болов. ХБНГУ-ын Эдийн засаг, технологийн яам, Зүүн Азийн нийгэмлэгээс зохион байгуулсан Германы бизнесийн төлөөлөгчдийн Монголд хийж буй айлчлалтай холбогдуулан хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, аж ахуйн нэгж, компаниудын түншлэл, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх зорилготой уг арга хэмжээнд Германы талаас 30 гаруй компанийн удирдлага, банк санхүүгийн мэргэжилтэн, хөрөнгө оруулагчид манай улсад ирэв.

2007.08.23.

ХБНГУ-ын Археологийн Хүрээлэнгийн Судалгааны газрыг Улаанбаатар хотод нээв.

ГТХАН (GTZ)-ийн Хотын хөгжил, барилгын салбар болон мэргэжлийн сургалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд "Байгалийн чулуун зам" төслийг хэрэгжүүлж Чойжин ламын музейн гадна тохижилтыг жишиг загвар болгон хийж гүйцэтгэн талбайн нээлтээ хийв. Тус талбайн нээлтэд ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Пиус Фишер, ГТХАН-ийн Латин

Америк, Азийн бүсийг хариуцсан зохицуулагч, ноён Гюнтер Дресрюссе, Монгол Улисын Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, ноён Ганхүү, Нийслэлийн Засаг даргын орлогч, ноён Б. Баатарзориг нарын албаны 40 гаруй хүн оролцов.

2007.08.23-26.

Берлин хотноо Олон улсын социалист залуучуудын холбооны 100 жилийн ойг “Энх тайван тэгш эрхийн төлөө 100 жилийн тэмцэл” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд уг арга хэмжээнд тус байгууллагын гишүүн МАСЗХ-ны төлөөлөгчид оролцов.

2007.08.26-29.

Улсын мэргэжлийн хяналтын газар, ГТХАН-ийн хамтын ажиллагааны хүрээнд “Монполимет”, “Алтан Дорнод Монгол” компанитай хамтран уул уурхайн нөхөн сэргээлтийн үзүүлэх сургалт болон загвар нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулав.

2007.08.30.

ГТХАН (GTZ) Хотын хөгжил, барилгын салбарыг дэмжих хөтөлбөрийнхөө хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Барилга, хот байгуулалтын яамтай хамтран “Угсармал орон сууцны барилгыг дулааны үр ашигтай болгон засварлах загвар төсөл”-ийн тухай хэвлэлээр танилцуулав.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн залуучуудад экологийн боловсрол олгох үйл ажиллагааны хүрээнд МУИС-ийн ОУХС-ийн 3-р дамжааны оюутан А. Гүнжидмаа ХБНГУ-ын Леверкусин хотноо болж буй олон улсын чуулга уулзалтад оролцож, уур амьсгалын өөрчлөлт, ус хамгаалах асуудлаар илтгэл тавив.

2007.09-р сар.

1995 онд байгуулсан Харилцааны үндсийн тухай Хамтарсан тунхаглалыг шинэчлэхээр манай талаас төслөө боловсруулан Германы талд гардуулав.

Худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаарх Монгол-Германы анхны Зөвлөлдөх уулзалт Берлин хотод болж, эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон Протоколд гарын үсэг зурав.

2007.09.05.

Ерөнхийлөгч Н. Энхбаяр Өргөмжит консулын алба байгуулагдсаны 15 жилийн ойг тохиолдуулан үр бүтээлтэй ажиллаж байгаа ХБНГУ-ын Франкфурт дахь Өргөмжит ерөнхий консул Дирк Пфайл, Андреас Питум нарыг "Найрамдал" медалиар шагнав.

ХБНГУ-ын Бундестагийн гишүүн, Гадаад бодлогын байнгын хорооны Монголыг хариуцсан гишүүн ноён Майнфренд Грунд болон Конрад Аденауерын сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Томас Шрапел нар Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга Д. Дорлигжав тэргүүтэй тус намын удирдлагуудтай уулзав. Уулзалтаар манай орны улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явц, өнөөгийн байдлын талаар ярилцахын зэрэгцээ Германы Христосын Ардчилсан Нам, Монголын Ардчилсан Нам хоорондын цаашдын хамтын ажиллагааны талаар саналаа солилцсон байна.

2007.09.06-07.

ГТХАН-ын "Байгаль хамгаалал байгалийн нөөцийн тогтвортой менежмент" хөтөлбөрөөс санаачлан Гүн галуут бааз дээр ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ТББ, байгаль хамгаалагчид зэрэг 94 оролцогчдын дунд "Ойн хуулийн хэрэгжилт ба засаглал" Хоёрдугаар зөвлөгөөнийг зохион байгуулав.

ХБНГУ-ын Засгийн газрын санхүүжилтээр ГТХАН-ээс хэрэгжүүлж буй Хотын хөгжил, барилгын салбар болон мэргэжлийн сургалтыг дэмжих хөтөлбөрийн зүгээс "Монгол-Германы эко-сити" нэртэй 1700 айлын орон сууцны хотхон барих төлөвлөгөөнийхөө тухай мэдээлэв.

2007.09.07-08.

Социалист интернациональч эмэгтэйчүүдийн байгууллагын 100 жилийн ойг тохиолдуулан ХБНГУ-ын Штутгарт хотноо "Жендерийн тэгш байдлыг хангах тэмцлийн тэргүүн эгнээнд 100 жил" уриан дор тэмдэглэж, манай улсаас МАСЭХ-ны тэргүүн Д. Алтай тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

2007.09.10.

"Герман-Монголын гүүр" ТББ-аас НХХЯ, Германы хөдөлмөр зуучлалын агентлагтай хамтран зохион байгуулсан "Хөдөлмөрийн бирж 2007" ажлын байрны өдөрлөг болов. Энэ онд гурав дахь удаагаа болж буй тус арга хэмжээнд дотоод, гадаадын 31 компани оролцож, ажлын 200 байр санал болгосон байна.

2007.09.12.

ГТХАН-ын "Байгаль хамгаалал байгалийн нөөцийн тогтвортой менежмент" хөтөлбөрөөс санаачлан Улаанбаатар хотод аж ахуйн нэгж, ТББ, модны худалдаачид, байгаль орчны байцаагчдын төлөөлөл 40 оролцогчдын дунд "Ойн хуулийн хэрэгжилт ба засаглал" Гуравдугаар зөвлөгөөнийг зохион байгуулав.

2007.09.13.

Берлин хотын Холбооны Эдийн засаг, технологийн яамны хурлын танхимд "Хот байгуулалт, байгаль орчны технологийн салбар дахь Монгол-Германы хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын боломж" сэдэвт Монголын эдийн засгийн өдөрлөг болов.

2007.09.14.

Германы Конрад Аденауерын сан, МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төв, Нээлттэй нийгэм форум, "Глоб Интернэшнл" ТББ хамтран "Сонгуулийн кампанийн коммуникаци: Өрнөдийн жишиг ба Монгол Улс" сэдэвт бага хурлыг зохион байгуулав. Бага хуралд оролцсон ХБНГУ-ын Кобленц Ландау Их Сургуулийн доктор Енс Теншер өрнөдийн сонгуулийн кампанийн загвараас танилцуулав.

2007.09.14-16.

Конрад Аденауерийн сан МоАХ-ны Дархан-Уул, Булган, Орхон, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгийн салбар байгууллагын 100 гаруй төлөөлөгчдийн дунд Дархан-Уул аймагт "Орон нутгийн өөрөө удирдах ёс" сэдвээр семинар явуулж, хэлэлцүүлэг зохион байгуулав.

2007.09.17-20.

Бундестагийн Ерөнхийлөгч ноён Норберт Ламмертийн урилгаар Монгол Улсын Их Хурлын дарга Д. Лүндээжанцан тэргүүтэй төлөөлөгчид ХБНГУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Бундестагийн Ерөнхийлөгчтэй уулзаж, Монгол Улсад Гёте институтын салбарыг нээх, Германд Монгол судлалын төв байгуулах, тус улсын хөрөнгө оруулалтаар Монголд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах, Монгол Улсын хөгжлийн цогц бодлого боловсруулахад Германы нэртэй эдийн засагч, эрдэмтдийн санал зөвлөгөөг авах талаар ярилцаж, манай улсад үзүүлдэг зээлжих эрхийн нөхцлөө хөнгөвчлөх тухай саналаа тавив. Айлчлалын хөтөлбөрийн дагуу УИХ-ын даргыг Бундестагийн Эдийн засаг, технологийн Байнгын хорооны дарга, Өргөдөл, гомдлын Байнгын хороо, түүнчлэн Холбооны Эдийн засаг, технологийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, ноён Бернд Пфафенбах нарын албаны хүмүүс хүлээн авч уулзсанаас гадна Баден-Вюртемберг, Берлин, Бранденбург муж улсад зочилж, Парламент, Засгийн газрын удирдлагуудтай уулзав. Айлчлалын хүрээнд олон бизнес ажил хэргийн уулзалт болов.

2007.09.25.

ГТХАН-ын "Байгаль хамгаалал байгалийн нөөцийн тогтвортой менежмент" хөтөлбөрөөс санаачлан Улаанбаатар хотод Байгаль Орчны Яам, Улсын Мэргэжлийн Хяналтын Газар, Цагдаагийн Ерөнхий Газар, байгаль орчны байцаагчдын төлөөлөл оролцсон "Ойн хуулийн хэрэгжилт ба засаглал" Дөрөвдүгээр зөвлөгөөнийг зохион байгуулав.

2007.09.27.

Спортын буу, сум үйлдвэрлэдэг Германы “Walter” группийн Ерөнхийлөгч Хайнц Вольф Пелаумер Монголд айлчилав. Тэрбээр Эрүүл мэндийн яамны дэд сайд Отгонболдтой уулзаж, Монголын буудлагын спортын хөгжлийн түүх, цаашдын төлөв, хамтын ажиллагааны боломжийн талаар ярилцахын зэрэгцээ МҮОХ-ны Ерөнхийлөгч Д. Загдсүрэнтэй уулзаж ярилцав.

2007.10-р сар.

Монгол-Германы Гадаад Хэргийн Яамдын Зөвлөлдөх уулзалт Берлин хотноо зохион байгуулагдав. Уг Зөвлөлдөх уулзалтаар дараа жилүүдэд солилцох өндөр, дээд хэмжээний төлөөлөгчдийн айлчлал, эдийн засаг, боловсрол, соёлын хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэв.

2007.10.08-10.

ХБНГУ-ын иргэн, хүнд машин, механизмын үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлдэг Либхерр группийн Ерөнхийлөгч Уилли Либхерр манай улсад “Моннис интернэшнл” компанийн урилгаар айлчилав.

2007.10.10.

МУИС-ийн Электрон микроскопын лабораторийн нээлт болов. Уг лабориторт бодисыг 200 мянга дахин өсгөх чадалтай, дэлхийн судалгааны томоохон төвүүдэд ашиглагддаг нарийн хэмжээст, орчин үеийн электрон микроскопыг суурилуулсан бөгөөд 200 мянган ам.долларын өртөгтэй энэ тоног төхөөрөмжийг ХБНГУ-ын Макс-Планкийн нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр тус сургуульд худалдан авч суурилуулжээ.

2007.10. 15.

2008-2009 онд ХБНГУ-ын Засгийн газраас олгох зээл, тусламжийн асуудлаар Монгол, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээрийн өмнөх хамтарсан зөвлөлдөх уулзалт Сангийн яаманд эхлэв. Зөвлөлдөх уулзалтыг Сангийн сайд Н. Баяртсайхан, ХБНГУ-аас Монгол Улсад суугаа

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд П. Пишер нар нээж үг хэллээ. Мөн үеэр Герман-Монголын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд олон жил үр бүтээлтэй ажилласан ХБНГУ-ын Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны Монголын газрын асуудал хариуцсан ажилтан, ноён Шейферийг энэ үеэр Сангийн яамны жуух бичгээр шагнав.

2007.10.17.

Монгол-Германы Гадаад яамдын консулын уулзалт Берлин хотноо болов.

Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GTZ)-ийн шугамаар агаарын чанарын мэдээг цаг тутам гаргах чадалтай автомат аппаратыг Улаанбаатар хотын Нисэх, Зурагт, 100 айл, Сонгино хайрхан дүүрэгт байрлуулахаар болов.

2007.11-р сар.

Манай улсын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн 42 хүний бүрэлдэхүүнтэй хэсэг Берлин хотод болсон олон улсын хөгжмийн наадамд анх удаа оролцов.

ХБНГУ-ын KFW банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 10.15 км хэсэгчилсэн хайрган хучилттай авто замын талаар холбогдох хүмүүсийг байлцуулан ярилцлага зохион байгуулан ажлаа эхлэв.

2007.11.05-08.

"Монгол-Германы геологийн хамтын ажиллагааны уламжлал, шинэ боломж" сэдэвт дугуй ширээний ярилцлага Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар болж, хоёр улсын мэргэжилтнүүд санал бодлоо солилцов. Дугуй ширээний ярилцлагын үеэр ХБНГУ-ын Геологийн шинжлэх ухаан, байгалийн эрдэс баялагийн хүрээлэнгийн Европ, Ази, Номхон далайн орнуудыг хариуцсан хэлтсийн дарга хатагтай Шварц Франка, геологич Олгеман Вальтер, Рауш Юрген нарыг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын "Хүндэт өргөмжлөл"-өөр шагналаа.

2007.11.06.

Монгол-Германы эрдэс баялагийн салбарын хамтын ажиллагаа үүсч хөгжсөний 45 жилийн ойн арга хэмжээг Үйлдвэр, худалдааны яам, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулав. Ойн арга хэмжээний үеэр "Монгол-Германы хамтын ажиллагаа геологи, эрдэс баялагийн салбарт" онол, практикийн бага хурал ШУТИС дээр зохион байгуулагдсан бөгөөд ҮХЯ-ны сайд Ц. Даваадорж Монгол-Германы хамтын ажиллагааг үйлдвэр худалдааны салбарт үүсгэн хөгжүүлэх, Монгол орны эрдэс баялагийг нээн илрүүлэхэд үнэтэй хувь нэмэр олруулсан Германы геологич доктор Роланд Узлауб, доктор Барт нарыг "Монгол Улсын тэргүүний геологич" цол тэмдгээр, доктор Анберт Камфпе, Ричард Люх, Клаусс Мисслинг, Аксел Майер, Хуберт Граупнер, Йоахим Штойбнер, Вальтер Фокел нарыг ҮХЯ-ны "Хүндэт жуух бичиг"-ээр шагнав.

2007.11.13.

ГТХАН-ын "Байгаль хамгаалал байгалийн нөөцийн тогтвортой менежмент" хөтөлбөр, Монгол Улсын Байгаль орчны яамтай хамтран Санкт-Петербургийн тунхагт гарын үсэг зуран нэгдэн орсноор "Ойн хуулийн хэрэгжилт ба засаглал" үйл ажиллагааг Монголд эхлүүлэн "Европ, Хойд Азийн орнууд (ЕХА)-ын ойн хуулийн хэрэгжилт ба засаглал (ОХХЗ)" үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх Андугаар зөвлөгөөнийг Төрийн ордын "Б" хурлын танхимд зохион байгуулав.

2007.11.15-16.

Монгол Улсын Байгаль орчны яам, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GTZ)-ээс хамтран Биологийн төрөл зүйл (БТЗ)-ийн Конвенцийн "Тусгай хамгаалалттай газар нутгийн хөтөлбөр" (ТХГНХ)-ийн Монгол Улс дахь хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны чиглэлийн үйл ажиллагааг дэмжигч талуудын зөвлөлдөх уулзалт Улаанбаатар хотноо болов. Уг зөвлөлдөх уулзалтад БТЗ-ийн Конвенцийн ТХГНХ хөтөлбөрийн төлөөлөл, БОЯ-ны Тусгай Хамгаалалттай Нутгийн Удирдлагын Газар, Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF), ГТХАН (GTZ), НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр (UNDP), Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO), Шинэ Зеландын

Байгалийн Хүрээлэн, Хүн төвтэй Байгаль хамгаалал (IPECON), Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS), Хустайн байгалийн цогцолбор газар, Дэлхийн банк (WB), АНУ-ын байгаль хамгааллын TNC төрийн бус байгууллагын төлөөллүүд илтгэл тавьж оролцов.

2007.11.19.

ХБНГУ-ын Ханс Зайделийн сангийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын шинэ байрны нээлт болж, Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Энхбаяр болон албаны бусад хүмүүс оролцлоо.

2007.11.20.

Ханс Зайделийн сан Нийслэлийн болон Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдэд зориулсан ээлжит сургалтаа эхлэв.

2007.11.22.

ГТХАН (GTZ)-ийн “Хуульчдын сургалт ба давтан сургалт” төслийн мэдээллийг “Өнөөдөр” сониноор дамжуулан олон нийтэд хүргэв. МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэн 2007 онд Улаанбаатар хотын 6 дүүрэг, Дархан, Ховд, Өмнөговь аймгийн шүүгч, шүүхийн шийдвэр биелүүлэгч, нотариатч, өмгөөлөгч, бизнес эрхлэгч, их, дээд сургуулийн багш, оюутан нийт 800 гаруй хүмүүсийн дунд уг төслийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар дэлгэрэнгүй судалгаа явуулахад судалгаанд хамрагдагсдын дийлэнх олонх нь ГТХАН-ийн эрхзүйн шинэтгэлийн төслийг үр дүнтэй, практик ач холбогдолтой сайн төсөл гэж үнэлжээ.

2007.11.23.

Үйлдвэр, худалдааны яамнаас Монгол Улсад Уул уурхайн салбар үүсч хөгжсөний 85 жилийн ойд зориулж “Монгол Улсад металлургийн аж үйлдвэрийг хөгжүүлэх боломж шаардлага” сэдэвт олон улсын зөвлөлгөөнийг зохион байгуулав. ХБНГУ-ын төлөөлөгчид тус хуралд өөрийн орны металлургийн салбарын хөгжлийн туршлагаас танилцуулав.

2007.11.28.

Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GTZ)-ийн Хотын хөгжил, барилгын салбар болон мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих хөтөлбөр (UDCP)-өөс "Барилгын дулаан тусгаарлалтын нэгдсэн систем" сэдэвт практик сургалтыг ШУТИС-ийн КТМС дээр 20 хоног зохион байгуулж дуусгав. Уг сургалтанд барилгын салбарын хувийн аж ахуйн нэгжүүдээс 20 орчим хүн хамрагдсан бөгөөд ГТХАН (GTZ)-ийн мэргэжилтэн Хэндрик Бэкер, Д. Энхтөр нар удирдан явуулжээ. Тэд сургалтаа PPP (Private Public Parthnership) хэлбэрээр явуулсан нь Монголд анхдагч зүйл болов.

Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний II Зөвлөгөөнийг БСШУЯ, ГТХАН (GTZ)-ийн Хотын хөгжил, барилгын салбар болон мэргэжлийн сургалтыг дэмжих хөтөлбөр (UDCP) хамтран Төрийн ордонд зохион байгууллаа. Зөвлөгөөнд Монголын ажил олгогч Эздийн Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч Ч. Нямсамбуу тэргүүтэй төлөөлөгчид болон ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд, ноён Пиус Фишер, ГТХАН (GTZ)-ийн Хотын хөгжил, барилгын салбар болон мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих төсөл (UDCP)-ийн захирал, хатагтай Рут Эрлбек нарын албаны хүмүүс оролцов. Өмнө нь БСШУЯ, ГТХАН (GTZ) хамтран "Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлгөөн"-ийг Төрийн ордонд энэ оны 3-р сарын 27 нд зохион байгуулжээ.